



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/22

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.4-ийн "д" заалт, Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.95 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвд баригдах 3000м³-ийн хүчин чадал бүхий Цэвэрлэх байгууламжийн төслийн багийг мэдээллээр хангах ажлын хэсгийг байгуулж бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Цэвэрлэх байгууламж барих төсөлд орон нутгаас шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авч, мэдээллийг үнэн зөв бодитоор мэргэжлийн өндөр түвшинд гарган хүргүүлж байх, төслийн ажлын явц болон Ажлын хэсгийн ажлын талаарх мэдээллийг тухай бүрд Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Аймгийн Засаг даргын орлогч/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч:	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга :	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Чингис хотын архитектор "Хэнтий-Ус" ХХК-ийн захирал "Хэнтий-Ус" ХХК-ийн Ариутгах татуургын инженер БНЗӨБЦТССалбарын Хэнтий аймгийн салбарын захирал